



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

додуц оны 04 сарын 08 өдөр

Дугаар 8/39

Улаанбаатар хот

Тамхи худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.14 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 8.2.11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдааны газрын стандартын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрнаас 500 метрийн тойргоос гадна байрлан үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгохыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагын нэrsийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилт, зөвшөөрөл авсан худалдаа үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД